



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 300

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 445,055,307.95 (дөрвөн зуун дөчин таван сая тавин таван мянга гурван зуун долоон төгрөг ерэн таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины 3 дахь дуудлагын худалдааг зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Бямбадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу байгууллагын дансанд төвлөрүүлэх;


2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн
 300 дугаар тогтоолын хавсралт



**"Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн
 үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, дахин нээлттэй
 дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиг лалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2017 оны 281, 590 дүгээр тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Бульдозер PR-732 L-01	2004	98000	442,733,307.95	10,000,000.00	5,000,000.00
2	ЗИЛ-130 /АЦ-40/, 59-04 УББ, галын автоцистерн, 151781, 2505201	1989	194486	2,322,000.00	2,000,000.00	1,000,000.00
	Нийт дүн			445,055,307.95 (дөрвөн зуун дөчин таван сая тавин таван мянга гурван зуун долоон төгрөг ерэн таван мөнгө)	12,000,000.00 (арван хоёр сая)	6,000,000.00 (зургаан сая)